



МОНГОЛ УЛС
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2020 оны 03 сарын 31 өдөр

Дугаар А/185

Чэнгис хот

Урьдчилан сэргийлэх
арга хэмжээг зохион байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, 29.1.3-ын "а", Мал амьтны эрүүл мэндийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1, 9.4, 9.5, 9.6, 9.7, 9.8, 9.9 дэх заалтуудыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Хэнтий аймгийн нутаг дэвсгэрт байгаа мал амьтныг халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх вакцинжуулалт, лабораторийн шинжилгээнд хамруулах төлөвлөгөөт арга хэмжээг 2020 оны 04 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн зохион байгуулсугай.

2. Мал амьтныг халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх, тандалт шинжилгээний арга хэмжээнд шаардагдах эм урвалж, биобэлдмэл, мэргэжлийн удирдлагаар хангаж ажиллахыг Мал эмнэлгийн газар /Н.Анхбаяр/-т, сум орон нутагтаа графикт хугацаанд нь шуурхай зохион байгуулж малчид, мал бүхий иргэдийг татан оролцуулж, хүн хүч, тээврийн хэрэгслээр хангаж ажиллахыг сумдын Засаг дарга нарт тус тус үүрэг болгосугай.

3. Мал эмнэлгийн арга хэмжээнд мал сүргээ бүрэн хамруулаагүй, хамруулахаас зайлсхийсэн, заавар журмыг баримтлаагүйн улмаас малын өвчин гарах нөхцөлийг бий болгосон малчин, мал бүхий иргэд, холбогдох албан тушаалтанд хуулийн дагуу хариуцлага тооцож, хяналт тавьж ажиллахыг Мал эмнэлгийн газар /Н.Анхбаяр/-т даалгасугай.

4. Мал эмнэлгийн урьдчилан сэргийлэх тарилга, оношлогоо, шинжилгээний гүйцэтгэлд хяналт шалгалт хийхэд шаардагдах зардлыг орон нутгийн төсвийн тарилгын үйлчилгээний хөлсний зардлаас санхүүжүүлэхийг Санхүү, төрийн сангийн хэлтэс /С.Нямдаваа/-т, удирдлага зохион байгуулалтаар хангаж ажиллахыг Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтэс /Э.Мөнх-Эрдэнэ/-т, гүйцэтгэлийг танилцуулж ажиллахыг Мал эмнэлгийн газар /Н.Анхбаяр/-т тус тус даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Н.ГАНБЯМБА